

“БАНУУН БҮСИЙН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙД ТАРХСАН ГОЦ ХӨНӨӨЛТ ДОТООД, ГАДААД ХОРИО ЦЭЭРТЭЙ ОРГАНИЗМТАЙ ТЭМЦЭХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зөвлөх үйлчилгээний ажил нь баруун бүсийн тариалангийн талбайд тархсан дотоод, гадаад хорио цээртэй болон гоц хөнөөлт организмын тархалтын хил хязгаарыг тогтоох, эрсдлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг туршилт, судалгааны арга ашиглан орон нутгийн болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулж цаашид тархахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд ургамал хамгааллын аргыг боловсруулах зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудын дагуу зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн:

1. Монгол улсад гадаад хорио цээртэй шимэгч ургамал болох ороонго болон дотоод хорио цээртэй, гоц хөнөөлт шавьж, өвчний тархалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх, тэмцэх аргын судалгаа хийх
2. Ургамлын гадаад хорио цээртэй шимэгч ургамал болон хог ургамал, гоц хөнөөлт шавьж, өвчнийг таних, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тэмцэх аргын чиглэлээр танхимын болон талбайн сургалт зохион байгуулах
3. Гадаад, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт зарим организмтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, устгах аргыг боловсруулах
4. Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Нэг. Монгол улсад гадаад хорио цээртэй ургамал болох ороонго болон дотоод хорио цээртэй, гоц хөнөөлт зарим шавьжийн тархалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх, тархсан талбайд тэмцэх арга хэмжээний хүрээнд дараахь ажлуудыг хийсэн.

1. Гадаад хорио цээртэй бүрэн шимэгч ургамал болох ороонгын хоёр зүйл (нангиад ороонго, европ ороонго Зураг.1) Ховд аймгийн Буянт, Булган, Ховд, Жаргалант, Говь-Алтай аймгийн Шарга сумын тариалангийн талбайд тархсан байсныг болон



Зураг.1

үр, жимснийхээ тусламжтайгаар усны урсгал (хавар цасны хайлсан устай хамт горхи, жалга, голын дагуу); салхи; хөрс; ургамлын гаралтай бүтээгдэхүүн; үрийн болон хүнсний материал; суулгац болон бусад бүтээгдэхүүн; хөдөө аж ахуйн машин механизмаар зөөвөрлөгдөн тархдаг ба эзэн ургамлаа бүрэн үхэлд хүргэж байгааг тогтоов.

2. Ховд аймгийн Булган сумын жимсний талбайд чавганы үрч эрвээхий, Увс аймгийн Тариалан, Улаангом, Ховд аймгийн Жаргалант сумын чацарганы талбайд дотоод хорио цээртэй шавьж болох чацарганы ялаа, Увс аймгийн Улаангом сумын байцаа, манжингийн эх ургамал дээр байцааны бөөс, Увс аймгийн Тариалан сумын үр тарианы талбайд дотоод хорио цээртэй өвчин болох хошуу будааны тоосон харуу, Ховд аймгийн Буянт, Ховд, Жаргалант, Увс аймгийн Улаангом, Тариалан, Баруунтуруун сумын төмсний талбайд дотоод хорио цээртэй фитофтор өвчин өргөн тархалттай байв. Эдгээр хөнөөлт организмтай хими, биологи, механик аргаар тэмцэх туршилт судалгааны ажлыг гүйцэтгэн тархалт болон хор хөнөөлийг нь зохих хэмжээгээр бууруулж болохыг тогтоов.




Зураг.2 Чацарганы бөөсний тархалт(Ховд, Жаргалан.2021.08.09)



Зураг.3 Нэг урхинд баригдсан чацарганы ялааны нягтрал (Ховд, Жаргалан.2021.08.09)



Зураг 4. Төмсний навч ишин дээрх фитоптор өвчний шинж тэмдэг



Зураг 5. Өвчинд өртсөн төмсний талбайн ерөнхий байдал:
А-Увс аймаг Улаангом сум, Б-Завхан аймаг Улиастай сум



Зураг 6. Байцааны бөөс (*Brevicoryne brassicae*)

- Ороонго нь эрсдэл өндөртэй хөнөөлт организм бөгөөд ороонготой тэмцэхэд эзэн ургамалтай нь хамт хадах, тусгаарлах зурвас хийх, таримлын төрөл болон талбай хооронд ургасан байдлыг харгалзан гербицидийг сонгон хэрэглэх ба бусад дотоод, гадаад хорио цээртэй хог ургамалтай мөн химийн аргаар тэмцэх нь үр дүнтэй болохыг тогтоосон. Жимсний үрч эрвээхий, чацарганы ялаа болон бусад

хөнөөлт шавьжтай хими ба биологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулсан.



Зураг.4 Гербицид шүршсэний дараахь ороонгын байдлыг ургаж байгаа ороонготой харьцуулсан байдал



Зураг.5 Чавганы нэг жимсэнд урч эрвээхэйн 2 хүрэнцэр ба нэг жимсэнд 1 хүрэнцэр байгаа нь

4. Гадаад, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлтэй организмын талаарх мэдээллийг гарган аймаг орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан ба УХЭШХ-ийн хөнөөлт организмын мэдээллийн санд оруулсан.

Хоёр. Гадаад хорио цээртэй шимэгч ургамал ороонго болон дотоод хорио цээртэй, гоц хөнөөлт зарим хөнөөлт шавьжийн тархалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх, тархсан талбайд тэмцэх арга хэмжээний хүрээнд танхимийн болон талбайн сургалтыг зохион байгуулсан. Үүнд

1. Ховд, Увс аймгийн тариаланчдад зориулан цахим-танхим, Баян-Өлгий, Увс, Завхан, Ховд, Говь-Алтай аймгийн тариаланчид, ногоочдод талбайн сургалтуудыг зохион байгуулж төмс хүнсний ногооны талбайн болон хүлэмжийн аж ахуйн таримлын хөнөөлт организмыг таних, тэмцэх, тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, жимс, жимсгэний талбайн хөнөөлт организмыг таних, тэмцэх, тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үр тариа, тэжээлийн болон тосны таримлын талбайн таримлын хөнөөлт организмыг таних, тэмцэх, тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдлэг олгосон.

2. Сургалтыг аймгуудын зарим төрийн байгууллагуудын ажилтан, мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын байцаагч нарын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.

Гурав. Монгол улсад гадаад, дотоод хорио цээртэй хөнөөлт организм нь манай оронд тархаагүй болон хязгаарлагдмал тархалттай байгаа тул эдгээр хөнөөлт организмыг тархахаас урьдчилан сэргийлэх, устгах аргыг боловсруулах зорилгоор тодорхой хэмжээний талбайд устгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

1. Ховд аймгийн Буянт, Ховд сумын төмс, лууван, сонгины талбайн гадаад, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт хог ургамалтай тэмцэх туршилт судалгааг дэвсгийн болон үйлдвэрлэлийн талбайд ургамал ургалтын үед болон тарималгүй талбайд ургамал хамгааллын бодис, бэлдмэл болон сүүлийн үеийн техник тоног төхөөрмж болох дрон, дүүжинт хор шүршигч ашиглан туршилт судалгааны ажлыг гүйцэтгэн үр дүнг тогтоон тодорхой хэмжээний талбайд устгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



Зураг 7. DJI Mavic Pro дроноор талбайд үйлдвэрлэлийн шүршилт хийгдэв (Улаангом. 2021.06.29).



Зураг 8. Гэрлэн урхи байрлуулалт(Ховд. Булган. 2021.08.06)

2. Ховд аймгийн Булган сумын чавганы талбайд хөнөөлт шавжийн судалгаа хийж биологийн бэлдмэл ашиглан тэмцэх арга хэмжээний туршилтыг гүйцэтгэсэн.



Зураг 9. Наалдуулагч урхи чавганы модонд(Урхи өлгөсөн эхний өдөр болон 10 дахь хоногт)



Зураг 10. Хүнсний ногооны талбай болон талбай хоорондах ороонго ба гербицид шүршиж байгаа байдал

3. Увс аймгийн Баруунтуруун сумын буудайн талбайн гадаад, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт хог ургамалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд дэвсгийн болон үйлдвэрлэлийн талбайд зонхилон тархсан дотоод хорио цээртэй, гоц хөнөөлт мөлхөө ягаан толгой, хүрэн ягаан ноной зэрэг хог ургамалтай тэмцэх арга хэмжээний туршилтыг ургамал ургалтын үед гүйцэтгэж мөн тодорхой хэмжээний талбайд устгах арга хэмжээг хэрэгжүүлсэн.
4. Увс аймгийн Баруунтуруун, Тариалан, Улаангом сумын жимс, жимсгэнэ, байцаа, манжингийн эх ургамал, буудай, төмсний талбайд тархсан гадаад, дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт шавьжийн судалгааг хийж, тэмцэх арга хэмжээг ургамал хамгааллын бодис, бэлдмэл ашиглан туршиж үр дүнг тогтоон, тэмцэх арга хэмжээг боловсруулан зөвлөмжид тусгасан.

Дөрөв. Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох зорилгоор дараах материалуудыг бэлтгэн боловсруулсан

1. Зөвлөх үйлчилгээний ажлын явцад зохион байгуулсан талбайн болон танхимийн сургалт, ургамал хамгааллын арга хэмжээг явуулж буй талаар видео бичлэг хийж олон нийтэд хүргэхэд бэлэн болгосон.
2. Зөвлөх үйлчилгээний ажлын үр дүнг үндэслэн гадаад хорио цээртэй зарим хөнөөлт организмын онцлог шинж, тэмцэх арга бүхий зөвлөмж болон гарын авлагыг боловсруулсан.
3. Дээрх аймгуудын агроном болон газар тариалангийн мэргэжилтнүүд, газар тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хүртээл болгох зорилгоор зөвлөх үйлчилгээний ажлыг эмхэтгэн аймаг бүрт илгээсэн ба Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны цахим хуудсанд байршуулахаар бэлтгэж байна.









